



МОНГОЛ УЛС  
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2021 оны 02 сарын 05 өдөр

Дугаар А/59

Ховд

Хөрөнгө гаргах тухай

Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалтуудыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2.3-д “Хүүхдэд ээлтэй аймаг болно” гэсэн арга хэмжээний хүрээнд гэмт хэрэг, зөрчилд хохирсон насанд хүрээгүй хүүхдээс мэдүүлэг авах, уулзалт ярилцлага хийх, таатай орчин нөхцлийг бүрдүүлэх зорилгоор насанд хүрээгүй хүүхдээс мэдүүлэг авах өрөөг тохижуулахад зориулж 4.880.000 төгрөгийг зарцуулсугай.

2. Дээрх арга хэмжээнд зарцуулагдах 4.880.000 төгрөг /дөрвөн сая найман зуун наян мянган/-ийн 2.440.000 төгрөг /хоёр сая дөрвөн зуун дөчин мянга/-ийг Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 2021 онд хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр арга хэмжээний 4.8 дахь заалт “Залуучуудын хөгжил” дэд хөтөлбөрөөс, 2.440.000 төгрөг /хоёр сая дөрвөн зуун дөчин мянга/-ийг тус хөтөлбөр арга хэмжээний 4.10 дахь заалт “Тайван амгалан Ховдчууд” хөтөлбөрөөс гаргахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга /Д.Энхболд/, аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга /Ч.Багдал/ нарт зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



Б.ДҮГЭРЖАВ